



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2025 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/155

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3.1, 24.3.4 дэхь заалт, 24.6 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5 дахь заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 08 дугаар тогтоол, 2025 оны 25/50 тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн аж албаны дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.3, 3.1.4 дэх заалт, Нийслэлийн засаг даргын 2025 оны А/554 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Самбалхүндэвийн хаалттай оршуулгын газрын дахин төлөвлөлтийн ажлын бэлтгэл хангах хүрээнд үзүүлэх зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Нью Семетри” ХХК-тай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын газар (Г.Билгүүн)-т, зөвлөх үйлчилгээний ажлын НХААГ/20250103644, 25/07-38 дугаартай гэрээт ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг “Чингэлтэй хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв” ОНӨААТҮГ-т үүрэг болгосугай.

2.Энэхүү тушаалын 1 дүгээр заалтад заасан ажилд шаардагдах 1,498,750,032 (Нэг тэрбум дөрвөн зуун ерэн найман сая долоон зуун тавин мянга гучин хоёр) төгрөгийг Хот тохижилтын бусад зардлаас захиалагчийн хяналтын тайланг үндэслэн гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч (Б.Халиун)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн удирдлагын газар (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА
Г.БАТЗОРИГ



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн
11/55 тушаалын хавсралт

САМБАЛХҮНДЭВИЙН ХААЛТТАЙ ОРШУУЛГЫН ГАЗРЫН ДАХИН ТӨЛӨВЛӨЛТИЙН
АЖЛЫН БЭЛТГЭЛ ХАНГАХ, ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ЗАРДАЛ

№	Зардлын нэр	Санхүүжих дүн
1	2	3
1	Самбалхүндэвийн хаалттай оршуулгын газрын дахин төлөвлөлтийн ажлын бэлтгэл хангах хүрээнд үзүүлэх зөвлөх үйлчилгээний ажил	1,498,750,032
Нийт		1,498,750,032

[illegible]

172501078